

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2025/016/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:narmandakhd@audit.gov.mn">narmandakhd@audit.gov.mn</a> Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:odkhuu@audit.gov.mn">odkhuu@audit.gov.mn</a> Аудитор: Б.Оюунхэрлэн Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:oyunkherlenb@audit.gov.mn">oyunkherlenb@audit.gov.mn</a> Аудитор: С.Энхбаатар Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatarsu@audit.gov.mn">enkhbaatarsu@audit.gov.mn</a> Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:siilegmaao@gudit.gov.mn">siilegmaao@gudit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл.....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл .....	11
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. Аудитын илрүүлэлт .....	14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ ОНӨААТҮГ-ЫН

ЗАХИРАЛ Г.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 86.0 хувиар үнэлж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	560,930,062.12	577,079,629.80
1.1.02	Дансны авлага	437,532,692.62	377,621,561.26
1.1.06	Бараа материал	90,258,490.38	121,597,172.42
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,800,000.00	12,800,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,101,521,245.12	1,089,098,363.48
1.2.01	Үндсэн хөрөнгө	17,698,826,321.27	16,745,275,345.88
1.2.02	Биет бус хөрөнгө	3,804,823,666.57	3,803,146,929.84
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,503,649,987.84	20,548,422,275.72
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,605,171,232.96</b>	<b>21,637,520,639.20</b>
2.1.1.01	Дансны өглөг	182,956,770.55	578,895,102.67
2.1.1.03	Татварын өр	312,827,107.01	376,650,727.71
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	103,858,480.07
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	495,783,877.56	1,059,404,310.45
2.1.2.01	Урт хугацаат зээл	2,856,238,054.38	2,856,238,054.38
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	1,287,418,807.06	1,287,418,807.06
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,143,656,861.44	4,143,656,861.44
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,639,440,739.00	5,203,061,171.89
2.3.01	Өмч: - төрийн	467,926,157.11	467,926,157.11
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,194,607,800.73	3,194,607,800.73
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	17,576,995,933.02	16,392,014,398.30
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-3,273,799,396.90	-3,620,088,888.83
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-346,289,491.93
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-3,273,799,396.90	-3,273,799,396.90
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,965,730,493.96	16,434,459,467.31
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>22,605,171,232.96</b>	<b>21,637,520,639.20</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,452,472,319.69	5,658,615,930.53
2	Борлуулалтын өртөг	6,244,991,873.39	6,593,586,655.96
3	Нийт ашиг (алдагдал)	-792,519,553.70	-934,970,725.43
8	Бусад орлого	2,351,904,351.97	2,245,773,157.62
8.1	Орлогын дүн	2,351,904,351.97	2,245,773,157.62
10	Ерөнхий ба удирдлагын зардал	206,294,521.91	224,676,205.12
12	Бусад зардал	1,828,464,126.18	1,432,415,719.00
12.1	Зардлын дүн	2,034,758,648.09	1,657,091,924.12
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-475,373,849.82	-346,289,491.93
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-475,373,849.82	-346,289,491.93
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-475,373,849.82</b>	<b>-346,289,491.93</b>

“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,188,014,417.80	8,446,421,479.62
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,067,292,669.82	8,258,025,602.40
1.1.6	Бусад мөнгөн орлого	120,721,747.98	188,395,877.22
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,357,749,649.67	8,430,271,911.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,612,424,391.65	2,782,637,909.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	818,300,162.97	775,091,325.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,023,806,991.00	912,312,279.06
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	346,424,438.59	387,158,009.52
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	262,288,794.00	201,080,318.90
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	630,693,012.08	844,611,094.75
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,501,845,859.38	2,527,380,975.03
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-169,735,231.87	16,149,567.68
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-169,735,231.87	16,149,567.68
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	730,665,293.99	560,930,062.12
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	560,930,062.12	577,079,629.80

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	17,580,345,608.40	57,812,507.30	21,300,692,073.54
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-2,856,238,054.38	-2,856,238,054.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-475,373,849.82	-475,373,849.82
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	-3,349,675.38	0.00	-3,349,675.38
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	17,576,995,933.02	-3,273,799,396.90	17,965,730,493.96
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	21,334,781.13	0.00	21,334,781.13
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	9,500,000.00	0.00	9,500,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-346,289,491.93	-346,289,491.93
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	-1,215,816,315.85	0.00	-1,215,816,315.85
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	16,392,014,398.30	-3,620,088,888.83	16,434,459,467.31

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,873.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн. Үүнд:

*Залруулсан алдаа:*

1. Үндсэн хөрөнгийн шинжтэй 2,900.0 мянган төгрөгийн компьютерыг бараа материалын дансанд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй, “Шүр захын орчим цэвэр усны шугамын ажил”-аар хийгдсэн 18,973.5 мянган төгрөгийн хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусад үндсэн хөрөнгөнд шилжүүлж бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Бараа материалын шинж агуулсан 19,000.0 мянган төгрөгийн “Дулааны 2-р хэлхээний гидролик тооцоо хийх аргачлалын бодлогын баримт бичиг”-ийг үндсэн хөрөнгөнд орлого авч бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5,327.8 сая төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 5,1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 32.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 3,165.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,327.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан ч материаллаг бус нийцлийн аудитын асуудал тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй 4 ажилтанд жилийн эцэст үр дүнгийн урамшуулал 3,539.4 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, байгууллагын Хамтын гэрээний 3.7-д “жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалт 13 дахь сарын цалин олгох бөгөөд энэхүү урамшууллыг сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд олгохгүй” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайланд хяналтын горим сорил хэрэгжүүлэхэд 1,582.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 1 ширхэг зөөврийн компьютер бодитоор байхгүй байна. /ашиглалтад орсон хугацаа 2022 он, балансын үнэ 3.1 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл 1.5 сая төгрөг/ Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх хэсгийн 3-д “агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 5.2 Албан шаардлага

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Тайлант хугацаанд Лэмдгэлиш ХХК-с худалдан авсан 32.1 сая төгрөгийн ажлын хувцсыг шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн үнээр жижиглэнгээр 1 өдөр /2025.03.31/, 1 компанитай 2 гэрээ /№11,12 дугаартай/ байгуулан худалдан авалтыг хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Бараа материалын нярав болон кассын нярвыг ээлжийн амралтын хугацаанд үндсэн хөрөнгийн нягтлан бодогчид хавсруулан ажиллуулах тушаал гаргаж, /гүйцэтгэх захирлын 2025.07.01-ны Б/133 тушаал/ нягтлан бодогч нь өөрийн ажлын байрны шууд харьяалах, хяналт тавих доод албан тушаалын буюу нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн байна. Энэ нь нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Ахмадын сангийн дансгүй ч байгууллагын данснаас ахмад настныг хүлээн авахад 5,835.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.2-д "Байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын сан байгуулж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 30 нэр төрлийн, тайлант хугацаанд нэмэгдсэн 48 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдэл тооцоогүй үндсэн хөрөнгөнд холбогдох журам, заавар, стандартын дагуу элэгдэл тооцож ажиллах

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн бүртгэлд үлдэх өртөггүй болсон 1969–1988 оны 41,836.1 мянган төгрөгийн, 1992–2024 оны 450 нэр төрлийн 1,776,221.7 мянган төгрөгийн хөрөнгө байна. Эдгээр хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, одоог хүртэл ашиглаж байгаа ч ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл, хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засвар сэлбэлт хийж өөр зориулалтаар ашиглах боломжтой эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулж ажиллах.

**4. Худалдан авах ажиллагаатай холбоотой**

**Илрүүлэлт:** Худалдан авах ажиллагааны цахим системээр цэвэр усны дамжуулах шугамын усны тоолуур худалдан авах 43.5 сая төгрөгийн, цэвэр усны ангийн уурын зууханд тогоо худалдан авах /HP60Ж/ 28.0 сая төгрөгийн, цэвэр усны төмөр шүүх станцын барилгын дээврийн их засварын ажил гүйцэтгэх 40.0 сая төгрөгийн тендерийг зарласан ч тендерийн үр дүнг оруулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.5-д "тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Худалдан авах ажиллагааны үр дүнг тухай бүр нь tender.gov.mn цахим системд оруулж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгө /компьютер/-ийг бараа материалаар бүртгэсэн	1	2900.0			1	2900.0						
Үндсэн хөрөнгийг шийдвэргүй хооронд нь шилжүүлсэн	1	18,973.5			1	18,973.5						
Бараа материалыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн	1	19,000.0			1	19,000.0						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>40,873.5</b>			<b>3</b>	<b>40,873.5</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй ажилтанд	1	3,539.4	1	3,539.4			-	-	-	-	-	-

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

урамшуулал олгосон												
Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаараас доош үнээр худалдан авалт хийсэн	1	32,060.0									1	32,060.0
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгө бодитоор байхгүй	1	1,582.3	1	1,582.3			-	-	-	-	-	-
Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж хэрэгжүүлээгүй	1	32,060.0			1	32,060.0	-	-	-	-	-	-
Няравын ээлжийн амралттай хугацаанд түүний ажлыг нягтланд хариуцуулсан	1	692.0			1	692.0	-	-	-	-	-	-
Ахмадын сан байгуулж ажиллуулаагүй	1	0.0					1	0				
Үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй	1	227,206.9					1	227,206.9				
Ашиглаж байгаа үлдэх өртөггүй болсон хөрөнгийн үнийг дахин шинэчлээгүй	1	1,818,057.8					1	1,818,057.8				
Худалдан авах ажиллагааны үр дүнг цахим системд оруулаагүй	1	111,500.0					1	111,500.0				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>2,226,698.4</b>	<b>2</b>	<b>5,121.7</b>	<b>2</b>	<b>32,752.0</b>	<b>4</b>	<b>2,156,764.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>32,060.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	1	3,127,352.4	-	-	1	3,127,352.4	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,127,352.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>3,127,352.4</b>	<b>-</b>	<b>-</b>